

ГАЗАР ХӨДЛӨЛТ

Олон нийтийн хэрэгцээнд зориулав




ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ: ГАЗАР ХӨДЛӨЛТ

СЭДВИЙН ЗОРИЛГО: Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, танин мэдэхүйн мэдлэг мэдээлэл өгөх.

АГУУЛГА:

- Газар хөдлөлтийн тухай ерөнхий ойлголт
- Монгол орны газар хөдлөлтийн ерөнхий зүй тогтол
- Япон улсын газар хөдлөлтийн сургамж
- Газар хөдлөлтөд хэрхэн бэлдэх вэ?
- Газар хөдлөлт болсон үед иргэдийн мэдвэл зохих зүйлс



ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ




“ГАЗАР ХӨДЛӨЛТ” ГЭЖ ЮУ ВЭ?

- Дэлхийн царцдас мандалд хуримтлагдсан хүчдэл огцом чөлөөлөгдөн уян харимхай долгион болон тархах үзэгдлийг **газар хөдлөлт** гэнэ.
- Өөрөөр хэлбэл таны алхаж буй газар нь дэлхийн чулуун мандалд үүссэн хүчдэлийн нөлөөгөөр долгисон хөдлөх үзэгдэлийг хэлнэ.



ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ЗҮЙ ТОГТОЛ Хавтангийн шилжилт – газар хөдлөлт



Дэлхийн царцдас мандалд хуримтлагдсан хүчдэл огцом чөлөөлөгдөн уян харимхай долгион болон тархах үзэгдлийг газар хөдлөлт гэнэ. Өөрөөр хэлбэл таны алхаж буй газар нь дэлхийн чулуун мандалд үүссэн хүчдэлийн нөлөөгөөр долгион хөдлөх үзэгдлийг хэлнэ. Энэ шилжилт хөдөлгөөний үндсэн дээр газрын гадаргад газар чичирхийлж хөдөлж байгаа юм. Газар хөдлөлтийг эх газрын ба далайн газар хөдлөлт гэж ангилдаг бөгөөд хавтангуудын хоорондын хөдөлгөөнөөс үүсдэг. Нэг том хавтан нөгөөгийнхөө доогуур шургах үед дээш түлхэгдсэн хавтан буцах харимхайн хөдөлгөөний үр дүнд дэлхийн хавтанд тодорхой өөрчлөлт гардаг. Япон Улсад тохиолдсон сургамжаас үзэхэд далайн доорх эх хавтангуудын шилжилтээс үүсэлтэйгээр ихэнхдээ далайн газар хөдлөлт тохиолдож байдаг учир нь далайн ёроол эх хавтангуудын заагууд байдагтай холбоотой. Их Канто, Токачигийн газар хөдлөлт болон 8 магнитудаас дээш газар хөдлөлтүүд бол энэ төрлийнх юм. Газар хөдлөлтийн хүчийг газар хөдлөлт бүртгэх багажинд бичигдсэн хөрсний шилжилтийн утгаар тодорхойлдог хэмжигдэхүүнийг **магнитуд** гэдэг.

ЗААВАРЧИЛГАА

- Хайчлахын өмнө хэсэг бүрийн ард талд нь дугаар бичихийг онцгойлон зөвлөж байна.
- Цавуудахаасаа өмнө дотогшоо болон гадагшаа нугалаасуудаа хийгээрэй.
- Хэсэг тус бүрийг шугамын дагуу анхааралтай хайчлаарай.
- Тасархай зураасын дагуу шугам ашиглан хялбархан нугалаарай.
- Том хэсгүүдийг нааж байхдаа хэзгийг наахаас болгоомжлоорой.

САНУУЛГА

- Танилцуулга, тайлбаруудыг анхааралтай уншиж, загварын хуудсан дээр харуулсан шиг дарааллыг бүрдүүлнэ.
- Энэхүү цаасан бэлцэц нь цавуу, хайч зэрэг хүүхдэд аюултай хэрэглэлүүд ашиглахыг санаарай.

ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХЭРЭГСЛҮҮД






ТЭМДЭГЛЭГЭЭ

- Нуруулдаж нугална (тасархай шугам)
- - - - - Хотойлгож нугална (цэгтэй, тасархай шугам)
- Хайчлах зураас (шулуун шугам)
- Чиглүүлэх зураас (тасархай шугам)
Цавуутай талуудыг энэхүү шугамын дагуу зэрэгцүүлэн наана.
- ➔ Сумны заасан чигт цавуудаж, зэрэгцүүлнэ.
- Цавуудах хэсэг (улаан цэг) • Эсрэг талыг цавуудна (ногоон цэг)

■ Цаасны эсрэг талыг тэмдэглэнэ

Тектоник хавтангууд болон тэдгээрийн харилцан үйлчлэл





МАГНИТУД БА БАЛЛЫН ЯЛГАА


Балл гэж юу вэ?

Тухайн газар хөдлөлт хүрээлэн буй орчин ба хүмүүст хэрхэн мэдэгдсэнээр тодорхойлогдох доргилтын хүчийг илэрхийлж байгаа хэмжигдэхүүнийг газар хөдлөлтийн **эрчим буюу балл** гэж нэрлэдэг.

МАГНИТУД БА БАЛЛЫН ЯЛГАА

Магнитуд (M) гэж юу вэ?

Газар хөдлөлтийн хүчийг газар хөдлөлт бүртгэх багажинд бичигдсэн хөрсний шилжилтийн утгаар тодорхойлдог хэмжигдэхүүнийг **магнитуд** гэнэ.






МАГНИТУД БА БАЛЛ/Эрчим/

Бага

Долгионы эрчим /балл/


Их



**ГАЗАР
ХӨДЛӨЛТ
/ M /**

Меркалийн хуваарь (Балл)	Рихтерийн магнитудийн эквивалент харьцаа	Гэрчүүдийн ажиглалт
I	1.0-2.0	Маш цөөхөн хүнд дөнгөж мэдэгдэхүйц төдий
II	2.0-3.0	Байшин барилгын дээд давхарт байгаа зарим хүмүүст мэдрэгдэнэ
III	3.0-4.0	Орон байр дотор байгаа хүмүүст анзаарагдана, тасалгаанд өлгөөтэй зарим эд зүйлс савлаж саржигнана.
IV	4	Ихэнх хүмүүст мэдрэгдэнэ, цонхны шил харнигнан сав суулга, хаалга чихарна.
V	4.0-5.0	Гадаа байгаа ихэнх хүмүүст болон байшин доторх бүх хүмүүст мэдрэгдэнэ. Барилга байшин чичирхийлнэ. Цонхны шил, барилгын шавардлагад цав гарна. Унтаж буй хүн сэрнэ.
VI	5.0-6.0	Бүх хүнд мэдрэгдэнэ. Хаалга савж, цонхны шил сав суулга хагарна. Тавиур дээрх эд зүйлс унаж дотор шавардлага хуурна.
VII	6.0	Чулуун барилгын хананд ан цав үүснэ
VIII	6.0-7.0	Газрын хөрсөнд хагарал үүснэ. Хөшөөнүүд унана. Барилга байшин гэмтэнэ.
IX	7.0	Тоосгон хана болон зарим барилга нурна. Худгийн усны түвшин өөрчлөгдөнө. Нуралт гулсалт үүснэ. Барилгын суурь суларч газар доорх хоолой эвдэрнэ.
X	7.0-8.0	Гүүр байшин барилга, барилгын суурь ус дамжуулах хоолой эвдэрч, хашлага далан сэтрэнэ. Газар дээр нурал ангал үүсч гол нуурын ус эргээсээ халина.
XI	8.0	Бараг бүх чулуун байгууламж эвдэрнэ, хөрсний шилжилт үүснэ
XII	8.0 түүнээс их	Бүх зүйл эвдэрч сүйднэ. Голын голидрол өөрчлөгдөн газар хөдлөлийн долгионууд газар дээр харагдаж хүнд жинтэй юмс ч агаарт шидэгдэнэ.


Газар хөдлөлтийн хүчийг тодорхойлох



МОНГОЛ ОРНЫ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ЗҮЙ ТОГТОЛ




МОНГОЛ ОРНЫ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ТӨВИЙН ТАРХАЛТ (1900-2000)



№	Газар хөдлөлт	Он сар өдөр	MI	Өргөрөг	Уртраг
1	Үнэгтэй	1903.02.01	7.5	43.4	104.5
2	Цэцэрлэг	1905.07.09	7.6	49.5	97.3
3	Булнай	1905.07.23	8.2	49.3	96.2
4	Монгол Алтай	1931.08.10	8.0	46.8	89.9
5	Говь-Алтай	1957.12.04	8.1	45.1	99.4
6	Баянцагаан	1958.04.07	6.9	45.1	98.4
7	Сайхан	1958.06.23	6.1	48.7	102.9
8	Буурын хяр	1960.12.03	6.7	43.2	104.4
9	Могод	1967.01.05	7.8	48.1	102.9
10	Үүрэг нуур	1970.05.15	7.0	50.2	91.3
11	Тахийн шар	1974.07.04	6.9	45.0	94.2
12	Цамбагарав	1988.07.23	6.0	48.6	90.6
13	Бүсийн гол	1992.12.27	6.2	50.9	98.2

МОНГОЛ ОРНЫ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ИДЭВХТЭЙ БҮС НУТГУУД



2008-2017 онуудад Монгол орны нутаг дэвсгэр болон хилийн ойролцоох бүс нутагт болсон магнитуд нь 2,5 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлтийн төвийн тархалтын зураг

- - Аймгийн төв
- ▲ - Газар хөдлөлт бүртгэх станц

ХҮЧТЭЙ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГОЛОМТОД БҮС НУТГУУД

**Булнай, 1905-07-09 $M=8.2$
хагарлын урт 370 км**



**Могод, 1967-01-05нд $M=7,1$
(хагарлын урт 45км)**




**Говь-Алтай, 1957-12-04нд $M=8,1$
(хагарлын урт 370 км)**



Говь-Алтай, 1957-12-04 газар хөдлөлтийн түүхээс

MI=8,1 (хагарлын урт 370 км)



ТҮҮХИЙН ХУУДАСНААС...

1957 оны 12 сарын 04-нд Говь-Алтайн нуруунд магнитуд нь 8.1 хүрсэн сүйрэлт газар хөдлөлт болсон.

Тус газар хөдлөлтөөр 10 хүн амь үрэгдэж



Хэдэн мянгаар
тоологдох мал
хорогдсон.




ТҮҮХИЙН ХУУДАСНААС...

1957 оны 12 сарын 04-нд Говь-Алтайн нуруунд магнитуд нь 8.1 хүрсэн сүйрэлт газар хөдлөлт болсон.


3 сумын байшин барилга бүрэн нурж сүйдсэн ба 5 сумын барилгууд ихээхэн гэмтсэн байна.



Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ /2013 он/



- 6.6-7.6 магнитудын газар хөдлөлт
- Барилга, байгууламжийн 22-50 орчим хувь
- 30-60 орчим мянган хүн



**ГАЗАР ХӨДЛӨЛТ ХҮНИЙ АМЬ НАСЫГ
ХОХИРООДОГ УУ?**



ЯПОН УЛСЫН СУРГАМЖААС... /КОБЭ ХОТ 1995 ОН/



Гэрэл зургийг: Кобэ хот

05:46 цагт М6.9 Газар хөдлөж
6,437 хүн нас барж, сураггүй алга болсон.

1925 оноос хойш 1995 он хүртэл 70 жилийн хугацаанд КОБЭ хотод томоохон газар хөдлөлт тохиолдоогүй байсан учраас энэ бүс нутагт хүчтэй газар хөдлөлт болно гэж таамаглаагүй байжээ.



Гэрэл зургийг: Кобэ хот



Гэрэл зургийг: Кобэ хот



Гэрэл зургийг: Кобэ хот

**Ханшин
хурдны
зам**



Гэрэл зургийг: Кобэ хот

ГАЛЫГ УНТРААХ БОЛОМЖГҮЙ
БАЙСАН



Гэрэл зургийг: Кобэ хот



Гэрэл зургийг: Кобэ хот



Гэрэл зургийг: Жобэ хот



Биеийн тамирын заал хоргодох байр болон хувирсан

Гэрэл зургийг: Кобэ хот



ТАНЫ ТООЦООЛООГҮЙ БҮХЭН ХАМГИЙН ХҮНДРЭЛТЭЙ АСУУДЛУУДЫГ БИЙ БОЛГОНО.

Гэрэл зургийг: Кобэ хот

Гэрэл зургийг: Кобэ хот



Гэрэл зургийг: Кобэ хот

Гэр бүлээ хайж буй хүмүүсийн мэдээллийг уншиж байна.

Гэрэл зургийг: Кобэ хот

1981 онд батлагдсан газар
хөдлөлтийн тэсвэржилтийн
зураг төслийн стандартад
нийцсэн барилга

1981 онд батлагдсан газар
хөдлөлтийн тэсвэржилтийн
стандартын өмнөх барилга

**ХАНШИН АВАЖИГИЙН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ДАРААХ
КОБЭ ХОТЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАРИЛГА**

Тухайн үеийн Кобэ хотын засаг захиргааны барилга...



Гэрэл зургийг: Кобэ хот



Гэрэл зургийг: Кобэ хот

Ажлын өрөө

Гэрэл зургийг: Кобэ хот



Модон барилга нурж, оршин суугчид нь дарагдан амь эрсдэж, зам хаасан байна.

Гэрэл зургийг: Кобэ хот



Байр сууцны гаднах байдал

Гэр доторх байдал



Гэрэл зургийг: Кобэ хот

Гэр доторх байдал



Гэрэл зургийг: Кобэ хот

**Ард иргэд газар
хөдлөлтийн
дараа бие
биедээ тусалсан
байдал**



Гэрэл зургийг: Кобэ хот

ХАНШИН АВАЖИ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН СУРГАМЖ

- Нийт аврагдсан хүмүүсийн 90-ээс дээш хувь нь өөрөө болон гэр бүл, хөршүүдийн тусламжтайгаар аврагдсан.
- Амь насаа алдсан хүмүүсийн 80%-нь орон сууц, өндөр байшингийн нурангад өртсөн.
- Амь эрсэдсэн хүний ихэнх нь газар хөдлөлтөөс хойш 15 минутын дотор нас барсан.



**МЭДЛЭГЭЭ ДЭЭШЛҮҮЛЖ
ОРОЛЦООГОО НЭМЭГДҮҮЛЭЕ**



Газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем



Улаанбаатар хотын 9 дүүрэгийн зарлан мэдээлэх дуут дохиоллын нийт 60 цамхаг, 3 телевиз 10 FM радиогоор гамшгийн дуут дохиог шууд өгнө. Гамшгийн дуут дохиогоор доорх мэдээллийг өгөх тул та бүхэн уг мэдээлэл авсан, сонссон даруйдаа цаг алдалгүй зааврыг дагана уу

Дуут дохиоллын цамхагийн цахим дэлгэцээр

Иргэдийн анхааралд: Газар хөдлөлтийн чичиргээ мэдрэгдсэн тул иргэн та дараах зааврыг дагана уу. Та барилга дотор байгаа бол цахилгааны болон хий, усны шугамыг хааж аюулгүй газар түр хүлээнэ үү. Чичиргээ зогссоны дараа та байгаа газраасаа тайван гарч аюулгүй талбайд очно уу. ОБЕГ



Газар хөдлөлтийн яаралтай мэдээ үзэх буюу сонссоноос хойш хүчтэй чичирхийлэл ирэх хүртэл хэдэн секундээс хэдэн арван секундын л хугацаа бий. Энэ богинохон хугацаанд биеэ хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай.




АМЖИЖ АНХААРУУЛАХ СИСТЕМ

Газар хөдлөлтийн аюулаас амжиж анхааруулах систем гэсэн ойлголтыг хугацаагаар төлөөлүүлэн харуулсан байна.



ГХАААС нь газар хөдлөлт болсоны дараа (хэдхэн секундын дотор) мэдээлэх систем юм. Өөрөөр хэлбэл нэгэнт болчихсон газар хөдлөлийг хохирол багатай даван туулахад чиглэгдсэн анхааруулга гэж ойлгож болно.

ГАЗАР ХӨДЛӨЛТӨНД ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?



ДАСГАЛ-2: БҮРҮРҮ


ХЭРХЭН ХИЙХ ВЭ? БЭЛТГЭХ АЖИЛ!



1 БЭЛТГЭХ АЖИЛ!
Буруу цаасан бэлдэцийг хийхэд бидэнд хайч, шугам, цавуу хэрэгтэй!
Амархан бөгөөд сайтар нугалахад шугам танд тус болно!



8 Зүүн талын зураг дээрх шиг болгосон уу!
Одоо зөвлүүлэх цаг боллоо!



2 Бэлдцээ зузаан цаасан дээр хэвлээрэй!



9 Холбогдох хэсгүүдийг наахад бэлтгээрэй!



3 Цэнхэр зураасаар хайчлах!
Бүх цэнхэр зураасыг дагуулан хайчлаарай.



10 Ижил дугаартайг хооронд нь наа!
Бэлдэц дээр 1-8 хооронд дугаарлагдсан байгаа.



4 Дээрийг зураасын дагуу хайчилж бэлтгээрэй!
Энэ үйлдлийг санаарай, хүмүүс мартчихдаг юм шүү.



11 Урьдчилан бэлтгэсэн завсар луу дээрийн хэсгийг оруулах!



5 Бэхлэгээг зураасын дагуу хайчилж бэлтгээрэй!



12 Хоёр бэхлэгээг Х үсэг шиг харагдахаар байрлуул!



6 Ногоон зураасаар нугалаарай!
Ногоон зурааснууд бол дотоги нугалах нугалаа. Шугам ашиглаж нугалсан хэсгээ босгоорой.



13 Бэхлэгээг Буруу руугаа оруулаарай!
Буруу цаасаа ширээн дээр тавиарай. 1 болон 2 давхартаа Х хэлбэртэй бэхлэгээг оруулах хэрэгтэй юм шүү.



7 Улаан зурааснуудаар нугал!
Улаан зураас бол гадагшаа нугалах нугалаа.




ДУУСЛАА!
ТА ЧАДЛАА!!
БАЯР ХҮРГЭ !!!



БУРУУ ЦААСАН БЭЛДЭЦ - ЗАГВАР.3.4

"Зөвлөгөө"


1. Тэмдэгтүүд дээр цавуугаа наах.
2. Ягаан сумны чигийн дагуу цэнхэр зураасаар хайчлах.
3. Ногоон өнгийн зураас бол дотоги буюу "уул" хэлбэртэй нугалаа, харин цэнхэр улаан өнгийн зураас нь гадагш нугалах буюу "хөндий" хэлбэрээр нугална.
4. Ижил дугаартай бэлдэцүүдийг хооронд нь нийлүүлж наана.

ЗААВАР. Хуруугаа суурь дээр нь байрлуулаад буруу-г хоёр тийш нь догсолгоно. Бэхлэгэнүүдийг нэг болон хоёрдугаар давхарт эсвэл зөвхөн хоёр давхарт байрлуулаад буруу-г хэрхэн ялгаатайгаар чичирхийлэхийг хараарай. Барилга хэзээ хамгийн их хөдлөх вэ? Дээрээ нэмж давхарлан, илүү хүнд болгоно. Буруу-гийн чичирхийлэлд дээрийн жин хэрхэн нөлөөлөх вэ?






ЭНГИЙН ҮЕД ГЭРИЙН ДОТОР ТАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАЖ ҮЗЬЕ




- ✓ Аюулгүй орон зай бүрдүүлэх
- ✓ Унжсан гэрлийн бүрхүүлийг бэхлэх
- ✓ Юм нурж ирэхээс сэргийлэх
- ✓ Тавилга унаж ирэхээс сэргийлэх
- ✓ Гарах гарцыг хааж эд зүйл тавихгүй
- ✓ Шил хагарахаас сэргийлэх



ХҮН НЭГ БҮРИЙН ҮҮРГЭВЧИНД БАЙХ 15 ЗҮЙЛ








ЭМНЭЛГИЙН
АНХНЫ ТУСЛАМХ

ЛААЗАЛСАН БОЛОН ХАГААСАН
ХАДГАЛАХ БОЛОМЖТОЙ ХҮНС



ДУЛААН ХУВЦАС ӨВЧТНИЙГ
ЗӨӨВӨРЛӨХӨД АШИГЛАНА.






БЭЭЛИИ ЦУВ
ХҮНС ХАДГАЛАХ
БЭЛТГЭХ САВ НӨМРӨГ ДЭВСГЭР



ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭГЭЭ
БОДОЛЦОЖ БЭЛТГЭЛЭЭ
ХАНГАХ




НЭМЭЛТ
ЗАЙ
НӨӨЦЛӨХ:



ТАНАЙ ГЭР, ОРОН СУУЦ ГАЗАР ХӨДЛӨЛТӨД БЭЛЭН ҮҮ?



Танай байшин хэзээ баригдсан бэ?



Танай байшин хир өндөр вэ?



Танай байшин баригдсан газар хэр хатуу хөрстэй вэ?

Аюулгүй байршил сонгох, гэр сууцаа засварлах, бэхэлгээ хийж, эрсдэлийг бууруулах

**ГАЗАР ХӨДЛӨЛТ БОЛСОН ҮЕД ТА
ЮУ ХИЙХ ВЭ?**



Газар хөдөллөө!!

Хамгийн түрүүнд Биеэ хамгаал!!!

Боломжтой бол: Гал гарч болох эх
үүсвэрүүдийг маш хурдан салгах, хаалга,
цонхоо онгойлго



Гэрт




- Толгойгоо хамгаалж, бат бөх ширээн доогуур орох, даацын хана налж суух зэргээр нуугдах.
- Сандралгүй тайван байж, шууд гадагш гүйж гаралгүй, чичирхийллийг намдтал хүлээ.
- Эрсдэлтэй гэж үзвэл галыг заавал унтраах шаардлагагүй.

1-2 минут !!

Чичирхийлэл намдмагц

- Гал гарч болох эх үүсвэрүүдийг шалгаж унтраана, цахилгаан таслах хөшүүргийг буулгаж, цахилгаан тасална.
- Гэр бүлийнхнийхээ эсэн мэнд эсэхийг тодруулна.
- Хагарсан шил зэргийг гишгэж гэмтэхгүйн тулд гутлаа өмсөнө.




Олон хүнтэй барилга байгууламж дотор

- Байгууламжийн ажилтны зааврыг дагах
- Ингэхдээ тайван байх сандарч, гарах хаалга руу шууд гүйхгүй



Цахилгаан шатанд

- Цахилгаан шат огт хэрэглэж болохгүй
- Хэрвээ цахилгаан шатанд суусан байсан бол хамгийн ойрхон давхарт зогсоож шууд буух



Уул хадтай ойрхон газар

- Чулуу унаж ирэх, хөрс нурахаас болгоомжлох

Гадаа (хот дотор) явж байсан бол



- Блокон хашаа нурж орж ирэх зэргээс болгоомжил
- Самбар, хагарсан шил унаж ирэхээс болгоомжил
- Бат бэх барилгын хажууд явж байгаа бол уг барилга руу орж аюулаас зайлсхий

Автомашин жолоодож явсан бол

- Огцом тоормос гишгэлгүй, хурдаа аажмаар бууруулан ослын дохионы гэрлээ асааж, бусад машинуудад анхаарахыг сануулах
- Хүчтэй чичирхийлэл мэдэрвэл замын хажуу талд түр зогсолт хийх



3 минут !!

Хүмүүсийн эсэн мэнд эсэхийг шалгах, гал түймэр гарахаас сэргийлэх

Ойр орчимд гал түймэр гарвал чанга дуугаар хүмүүст мэдэгдэж анхан шатны гал унтраах арга хэмжээ авна.

- Ойр хавийнхан харилцан бие биенийхээ эсэн мэнд эсэхийг шалгаж, туслалцана.
- Дараагийн чичиргээнээс болгоомжлох

5 минут !!

- Дүрвэж гарахдаа шатдаг хийн хоолой, цахилгаан таслах хөшүүргийг дахин шалгах.
- Бэртсэн, шархадсан хүмүүсийг аврах, анхны тусламж үзүүлэх
- Гамшигтай тэмцэх байгууллага болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж буй мэдээтэй танилцах



10 минут өнгөрсөнөөс хойш!!

Хүчээ нийлүүлэн гал унтраах,
аврах, яаралтай тусламж үзүүлэх
ажиллагаанд орох

Цуу ярианд автахгүй байх

Гамшиг, хохирлын мэдээг нэгтгэж цуглуулах
Харилцан туслалцах сэтгэлтэй байх

ГАЗАР ХӨДӨЛСНИЙ ДАРАА ГАРЧ БОЛОХ АСУУДЛУУД...

- Гэр, орон сууцны эвдрэлээс оршин суугчид амь насаа алдана.
- Амьдрах орон байраа алдаж сэтгэл санааны хямралд орно.
- Барилгын нуранги замыг хааж, сэргээн босголтод саад болно...

Анхаарал хандуулсанд баярлалаа

Аюулгүй ирээдүй айл өрхөөс



АННААР APP

- Гамшиг, ослын үед авах арга хэмжээ
- Холбоо барих байгууллагууд болон утасны дугаарууд
- Амилуулах суурь тусламжийн зааврууд
- Гамшиг, ослын үед ашиглах хэрэгслүүд



www.ontsgoisur.gov.mn

